6-р цэцэрлэг	88.5	68.4	-20.1
7-р цэцэрлэг	107.0	109.2	2.2
8-р цэцэрлэг	76.5	85.1	8.6
9-р цэцэрлэг	74.7	73.1	-1.6
10-р цэцэрлэг	52.9	52.9	-0.1
11-р цэцэрлэг	76.3	71.2	-5.1
12-р цэцэрлэг	35.4	37.5	2.2
Бүрэнхаан 13-р цэцэрлэг	131.2	157.6	26.5
14-р цэцэрлэг	43.2	42.0	-1.2
15-р цэцэрлэг	66.2	61.3	-4.9
Гэгээрэл төв	4.8	8.2	3.4
Дэлгэр Мөрөн цогцолбор сургууль	210.1	235.4	25.3
Титэм 2-р ахлах сургууль	158.9	163.2	4.3
Эрдмийн далай цогцолбор сургууль	217.9	247.2	29.2
Ирээдүй ахлах сургууль	93.2	108.5	15.4
Гурван Эрдэнэ ахлах сургууль	107.2	145.2	38.0
Нутгийн аваргууд спортын ахлах сургууль	71.8	94.7	22.9
Авьяас мэргэжлийн сургалттай ахлах сургууль	217.8	263.3	45.5
Сод Эрдэм сургууль	89.0	137.5	48.6
Нийт дүн	2,578.7	3,038.3	459.6

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны материаллаг өөрчлөлтөд ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтыг Бараа материал дансанд бүртгэсэн үлдэгдэл 51.6 сая төгрөгөөр өссөн, ЗДТГ-т Германы Ковид төслийн хүрээнд хамгаалах хэрэгслийн үлдэгдэл болон өвс тэжээлийн нөөцийн



үлдэгдэл 62.6 сая төгрөгөөр өссөн, ӨЭМТ-дэд Эрүүл мэндийн газраас олгосон Хамгаалах хэрэгслийн үлдэгдэл 47.6 сая төгрөгөөр өссөн, Ойн анги үнэт цаас, мод үржүүлгийн суулгацын үлдэгдэл 6.1 сая төгрөгөөр өссөн, 2-р цэцэрлэг тоглоом, урсгал засварын материал авснаар 35.2 сая төгрөгөөр өссөн, 4-р цэцэрлэг нормын хувцас, цагаан хэрэглэл, хичээлийн хэрэглэгдэхүүн 14.0 сая төгрөгөөр өссөн, 6-р цэцэрлэг хангамжийн материал акталсан 20.1 сая төгрөгөөр буурсан, 8-р цэцэрлэг даацын хулдаас авсан, яамнаас ирсэн тоглоом сургалтын хэрэглэгдэхүүн 8.6 сая төгрөг, 13-р цэцэрлэг 26.5 сая төгрөгөөр өссөн, ДМЦС химийн лабораторид Боловсролын яамнаас хичээл сургалтын хэрэглэгдэхүүн олгосноор 25.3 сая төгрөгөөр өссөн, ЭДЦС хичээлийн хэрэглэгдэхүүн, хамгаалах хэрэгсэл 29.2 сая төгрөгөөр өссөн, Ирээдүй сургууль хичээлийн хэрэглэгдэхүүн болон урсгал засварын материал 15.4 сая төгрөгөөр өссөн, Гурван-Эрдэнэ сургууль хичээлийн хэрэглэгдэхүүн болон урсгал засварын материал 38.0 сая төгрөгөөр өссөн, Сод эрдэм сургууль ХБИ-ий танхимын хичээлийн хэрэглэгдэхүүн яамнаас олгосон, хамгаалах хэрэгслийн үлдэгдэл 48.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж нөлөөлсөн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 49,450.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 62,281.5 сая төгрөг болж 12,830.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Дэлгэрмөрөн ӨЭМТ	175.1	198.7	23.6
Энэрэл ӨЭМТ	183.9	219.8	35.9
Гурван Эрдэнэ ахлах сургууль	2,864.5	2,904.3	39.8
9-р цэцэрлэг	689.9	711.0	21.1
8-р цэцэрлэг	454.5	472.7	18.2
Далайн Элбэрэлт ӨЭМТ	476.5	487.3	10.8
Бүрэнхаан 13-р цэцэрлэг	1,935.6	1,909.9	-25.7
Нутгийн аваргууд спортын ахлах сургууль	1,249.0	1,264.0	15.0
10-р цэцэрлэг	802.9	823.1	20.2
11-р цэцэрлэг	711.4	713.0	1.6
Авьяас мэргэжлийн сургалттай ахлах сургууль	424.2	502.0	77.8
Ойн анги	16.7	11.9	-4.9
Гэгээрэл төв	2.5	31.7	29.1
Гурван гал ӨЭМТ	271.6	321.3	49.7
Энх-Үйлс ӨЭМТ	103.4	138.1	34.7
12-р цэцэрлэг	914.4	925.7	11.3
Сод Эрдэм сургууль	5,281.5	5,360.9	79.5
14-р цэцэрлэг	1,464.0	1,438.5	-25.5
15-р цэцэрлэг	929.2	1,015.1	85.9
1-р цэцэрлэг	1,095.2	1,113.4	18.2
Засаг даргын тамгын газар	15,659.7	24,385.7	8,726.0
2-р цэцэрлэг	809.5	790.7	-18.7
3-р цэцэрлэг	788.6	783.6	-5.0
4-р цэцэрлэг	661.1	665.2	4.1
5-р цэцэрлэг	793.4	696.8	-96.6
6-р цэцэрлэг	376.2	387.2	11.0
Дэлгэр Мөрөн цогцолбор сургууль	1,940.5	5,200.1	3,259.6
Титэм 2-р ахлах сургууль	2,713.8	2,863.7	149.9
Эрдмийн далай цогцолбор сургууль	1,434.8	1,611.5	176.8
Ирээдүй ахлах сургууль	3,511.6	3,599.5	87.9
7-р цэцэрлэг	704.8	720.7	15.9
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	11.0	14.7	3.7
Нийт дүн	49,450.8	62,281.5	12,830.7

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байдлыг авч үзвэл: Худалдан авсан 829.6 сая төгрөг, хандиваар 32.3 сая төгрөг, шилжүүлсэн авсан 510.5 сая төгрөг, төсвийн хөрөнгө



оруулалтаар 15,670.5 сая төгрөг, шинээр ашиглах жил үнэ тогтоосон хөрөнгө 516.6 сая төгрөг байна.

Хөрөнгийн зарлага болгосон байдлыг авч үзвэл: Тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 3,270.5 сая төгрөг, өмнөх онд хамаарах элэгдэл 14.5 сая төгрөг /тооцооллын зөрүү/байна.

АИТХ-ын 2021 оны 111 дүгээр тогтоолоор нийт 1,865.2 сая төгрөгийг 0 үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хасаж ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн 516.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн эхний үлдэгдэл 5,396.6 сая төгрөг эцсийн үлдэгдэл 7,218.9 сая төгрөг байна. Тайлант онд ашиглалтгүй байгаа 4.5 сая төгрөгийн программ хангамж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 5.3 сая төгрөг байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 89.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 40.2 сая төгрөг болж 49.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Орон нутгийн хөрөнгө оруулалт	2.6	2.6	-
Орон нутгийн хөгжлийн сан	0.4	0.4	-
Барьцаа	47.0	35.5	-11.5
8-р цэцэрлэг	6.0	-	-6.0
Бүрэнхаан 13-р цэцэрлэг	7.6	-	-7.6
Нутгийн аваргууд спортын ахлах сургууль	0.8	-	-0.8
11-р цэцэрлэг	1.7	-	-1.7
Ойн анги	2.0	1.8	-0.3
12-р цэцэрлэг	0.5	-	-0.5
Сод Эрдэм сургууль	2.3	-	-2.3
1-р цэцэрлэг	1.5	-	-1.5
Засаг даргын тамгын газар	6.2	-	-6.2
2-р цэцэрлэг	1.4	0.0	-1.4
3-р цэцэрлэг	1.9	-	-1.9
4-р цэцэрлэг	4.6	-	-4.6
5-р цэцэрлэг	1.2	-	-1.2
6-р цэцэрлэг	1.3	-	-1.3
Титэм 2-р ахлах сургууль	0.2	-	-0.2
7-р цэцэрлэг	0.4	-	-0.4
Нийт дүн	89.5	40.2	-49.3

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өр төлбөрийн 35.5 сая төгрөг хугацаа болоогүй Чанарын баталгааны өглөг, хөрөнгө оруулалтын үлдэгдэл санхүүжилт 3.0 сая төгрөг, Ойн анги судалгаа хөгжлийн төвд үнэт цаасны тооцооны өглөг 1.8 сая төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо данс

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 53,892.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 67,696.6 сая төгрөг болж 13,804.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,597.4	19,694.5	2,097.1
Өмч /ТӨҮГ/	19.4	19.4	-



Хуримтлагдсан үр дүн	25,783.3	37,496.7	11,713.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,492.5	10,486.0	(6.5)
Нийт дүн	53,892.6	67,696.6	13,804.0

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 11,713.4 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын сан данс ЗДТГ нь 21 байрлалд газар орлогод авсан 1,923.5 сая төгрөг, 15-р цэцэрлэг 5-р цэцэрлэгээс газар шилжүүлэн авч бүртгэлд тусгасан 107.1 сая төгрөг, 7-р цэцэрлэг газрын хэмжээний зөрүүгээр орлого авсан 15.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хассаны зөрүү 6.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлогыг 47,659.3 сая төгрөгөөр тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 12,755.6 сая төгрөг буюу 36.6 хувиар өссөн байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	1,942.4	2,153.5	211.1	10.9
Татварын бус орлого	6,713.1	18,237.4	11,524.4	71.7
Тусламж санхүүжилтийн орлого	26,248.2	27,268.3	1,020.1	3.9
Нийт дүн	34,903.7	47,659.3	12,755.6	36.6

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны орлогыг өмнөх үетэй зэрэгцүүлбэл: Татварын бус орлого 11,524.4 сая төгрөгөөр өссөн, тусламж санхүүжилтийн орлого 1,020.1 сая төгрөгөөр өссөн байна.

Сумын ЗДТГ-т 9,8км 7,902.14 сая төгрөгийн өртөг бүхий УТХО-аар авто зам орлого авсан. ДМЦС-д 320 хүүхдийн хүчин чадалтай 3,105.38 сая төгрөгийн өртөг бүхий шинэ сургуулийн барилгыг УТХО-аар хүлээн авсан нь татварын бус орлогын өсөлтөд нөлөөлсөн.

Тусламж санхүүжилтийн орлогод ӨЭМТ-үүд ЭМД-ын сангаас төлбөрт үйлчилгээний санхүүжилтэд 1,183.54 сая төгрөг авсан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 35,932.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	30,063.1	34,625.1	4,562.0	5.2
Үйл ажиллагааны бус зардал	213.8	1,307.8	1,094.0	11.7
Нийт дүн	30,276.9	35,932.9	5,656.0	8.7

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант 2021 онд өмнөх оноос 5,656.0 сая төгрөгөөр их зардал гаргаж ажилласан байна.

Үйл ажиллагааны зардал өссөн шалтгаан нь ЭМД-ын санхүүжилттэй уялдан ӨЭМТ-үүдийн Бараа үйлчилгээний бусад зардлын өсөлттэй холбоотой байна.

Үйл ажиллагааны бус зардлын өсөлт нь Нутгийн аваргууд сургууль хуучин бага сургуулийн барилгыг АЗДТГ-т шилжүүлсэн, 5-р цэцэрлэгээс 15-р цэцэрлэгийн газрыг шилжүүлсэнтэй холбоотой.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” –ын хэрэгжилтийг хэрэгжилтийг хянан үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:



- Сумын ЗДТГ - Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй 11.9 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна
- Сумын ИТХ - Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4, 1.5, 1.6, 1.9 заалттай нийцэхгүй 9.3 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар ТЕЗ-ийн өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төслийг хэлэлцэн 02 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 27,624.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийж 1,265.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 28,889.3 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт 28,889.3 сая төгрөгийн зардлын 2,825.1 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 21,700.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 840.0 сая төгрөгийг ОНХНС-аас, 2,365.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 200.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс, 71.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, давсан орлого дансны үлдэгдлээс 886.7 сая төгрөгөөр төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Мөрөн сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 12 сарын 18-ний 02 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 2,365.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,820.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 119.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	188.2	245.9	57.8	130.7
Хөрөнгийн орлого	828.5	978.1	149.6	118.1
Шууд бус орлого	169.1	172.2	3.1	101.8
Хөрөнгө борлуулсны орлого	202.0	253.2	51.2	125.3
Бууны албан татвар	8.9	9.8	0.9	110.3
Малд ногдуулах албан татвар	20.0	68.0	48.0	340.2
Улсын тэмдэгтийн хураамж	30.8	30.9	0.1	100.4
Түгээмэл тархацтай АМАТ	10.6	10.7	0.0	100.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	345.2	309.0	-36.2	89.5
Газрын төлбөр	64.9	73.3	8.5	113.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.2	0.2	-	100.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.6	1.6	0.0	101.2
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	0.5	0.7	0.2	131.3
Татварын орлогын дүн	1,870.4	2,153.5	283.1	115.1
Торгуулийн орлого	495.0	666.7	171.7	134.7
Түрээсийн орлого	-	0.3	0.3	
Татварын бус орлогын дүн	495.0	667.0	172.0	134.7



Нийт орлогын дүн	2,365.4	2,820.5	455.1	119.2
-------------------------	----------------	----------------	--------------	--------------

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Сумын орон нутгийн орлого 455.1 сая төгрөгөөр давсан нь үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, малд ногдуулах албан татварын орлого, торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелснээс шалтгаалсан байна.

Айл өрхүүдийн Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Засгийн газраас хөнгөлсөн боловч 11, 12 дугаар сарын төлбөрийг сумын орон нутгийн орлогод нөхөн төвлөрүүлээгүйгээс 36.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 7,034.4 сая төгрөгөөр төлөвлөж 7,880.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 845.9 сая төгрөг буюу 12.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	НИЙТ	7,034.4	7,880.2	845.9
	Татварын орлого	6,413.1	7,162.4	749.3
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	5,000.0	5,578.0	578.0
2	АТБӨЯХАТ	340.0	344.5	4.5
3	Зам ашигласны төлбөр	71.7	76.2	4.5
4	Улсын тэмдэгтийн хураамж	252.6	284.6	32.1
5	Үл хөдлөх хөрөнгө	599.8	584.9	-14.9
6	Газрын үл хөдлөх хөрөнгө	-	0.2	0.2
7	Газрын төлбөр	130.3	154.0	23.7
8	Үйлдвэр үйлчилгээний ус ашигласан төлбөр	18.8	26.2	7.4
9	Татварын торгууль	-	75.1	75.1
10	Татварын алданги	-	38.7	38.7
	Татварын бус орлого	621.3	717.8	96.6
1	Татварын бус хүү торгуулийн орлого	435.8	240.8	-194.9
2	Санхүү төрийн өмчийн байгууллагын шилжүүлсэн ашиг /хувьцааны ногдол ашиг/	45.0	180.0	135.0
3	Хөрөнгө худалдсаны орлого	35.0	109.7	74.7
4	Түрээсийн орлого	5.5	13.7	8.2
5	Газрын суурь хураамж	-	107.3	107.3
6	Нэр заагдаагүй бусад орлого	100.0	66.4	-33.6

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 6,252.9 сая төгрөгөөр төлөвлөж 5,642.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 610.1 сая төгрөгийн тасралттай буюу 85.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	1,319.1	1,123.6	-195.5
2	НӨАТ	4,825.8	4,340.6	-485.2
3	Онцгой албан татвар	69.9	93.3	23.4
4	Ашигт малтмал/нүүрс	-	38.0	38.0
5	Ус бохирдуулсны төлбөр	2.4	7.2	4.8
6	Агаарын бохирдол /авто/	35.7	38.0	2.4
7	Агаарын бохирдол /нүүрс/	-	0.1	0.1
8	Агаарын бохирдол /эх үүсвэр/	-	2.0	2.0
	ДҮН	6,252.9	5,642.8	-610.1

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга



Улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос ААНОАТ- 195.5 сая төгрөг, НӨАТ- 485.2 сая төгрөгөөр тус тус материаллаг хэмжээгээр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 26,248.2 сая төгрөгөөр төлөвлөж, 27,268.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 103.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 28,889.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 27,975.2 сая төгрөгийг урсгал зардалд, 539.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 374.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн хуваарийн дагуу аймгаас авах санхүүгийн дэмжлэг 2,825.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжиж, тусгай зориулалтын шилжүүлэг 21,700.0 сая төгрөгийн санхүүжилт авч 100 хувийн гүйцэтгэлтэй, ОНХС-ын шилжүүлгээр 840.0 сая төгрөг авахаас бүрэн санхүүжиж харьяа байгууллага, тусгай сангуудад санхүүжилтийг бүрэн олгож ажилласан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 374.4 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 330.0 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

Төсвийн зарлагын талаар:

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 28,271.6 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хэрэгжсэнтэй холбоотой зарим зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 71.6 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 55.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 35.9 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 6.5 сая төгрөг
- Нормативт зардал 70.7 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 3.7 сая төгрөг
- Томилолт, зочны зардал 3.1 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 5.6 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 6.6 сая төгрөг
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 18.5 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 276.4 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангаас 330.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 122.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 200.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 12 төсөл, арга хэмжээнд 423.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 182.8 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 274.8 сая төгрөг байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн дүн болох нийт 7,190.3 сая төгрөгийн гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудын урсгал үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн дүн болох нийт 7,223.1 сая төгрөгийн гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 158.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 168.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 137.2 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 56.9 сая төгрөг нийт 521.3 сая төгрөгийг орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд чанаргүй зээлийн үлдэгдлийг 50% бууруулсан үзүүлэлттэй байна. Зээлийн хүү 17,1 сая төгрөг, үндсэн зээлийн эргэн төлөлт 413,3 сая төгрөг, алданги 10,8 сая төгрөг нийт 441,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны эцэст 281.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй байна.

Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих бусад мэдээллээс 9 дүгээр сарын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын 23.5 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэх системд байгууллагын нэрийг үнэн зөв мэдээлээгүй, байгууллагын гэрчилгээний нэр, улсын бүртгэл дэх нэр, дүрмийн сангийн дүн зөрүүтэй байна. Зөрчилтэй холбоотой зөвлөмжийг төсвийн шууд захирагчид хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй зөрчил илэрсэн байна.



3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2022 оны төсвийн талаар баримтлах бодлогын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн орлогыг батлагдсан нэр төрлөөр биелүүлсэн эсэх, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын хэрэгжилтийг хянан үзэх нь зүйтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил давтагдсан байгууллагын дарга, нягтлан бодогч нарт дараагийн аудитаар хариуцлага тооцох саналыг хүргүүлэх болно.

1. 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 31 төсвийн байгууллага, 5 орон нутгийн тусгай сан, 6 ОНӨААТҮГ, нийт 43 санхүүгийн тайлан, 43 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэнээс 24 байгууллагад дүгнэлт гаргаж, 19 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Дүгнэлт авах байгууллагууд бүгд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 350.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 23.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,694.2 сая төгрөгийн 60 алдаа, зөрчил илэрсэнд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 333.2 сая төгрөгийн 22 алдаа залруулж, 109.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 288.1 сая төгрөгийн 20 зөвлөмж, СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудалтай холбоотой 15 зөрчилд 963.7 сая зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд алдаа залруулаагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны эцэст 281.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн 281.8 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэн, хугацаа хэтэрсэн зээлийн авлагагүй байх.

2. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал:



Илрүүлэлт: Айл өрхүүдийн Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Засгийн газраас хөнгөлсөн боловч 11, 12 дугаар сарын төлбөрийг сумын орон нутгийн орлогод нөхөн төвлөрүүлээгүйгээс 36.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэр төрлөөр бүрэн биелүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байх.

3. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРСАН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,694.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тул хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Залруулааг үй алдаа		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал										
Мөрөн сумын ТТЗ	6	230.7	2	10.1			1		3	220.6
Харьяа байгууллагуудын зөрчил										
Мөрөн сумын ЗДТГ	2	13.4		-				-	2	13.4
Дэлгэрмөрөн цогцолбор сургууль	2	86.4	1	1.0			1	85.4		-
Титэм ерөнхий боловсролын сургууль	2	39.1		-			1	23.7	1	15.4
Нутгийн-Аваргууд спортын ахлах сургууль	8	105.0	4	58.3				-	4	46.7
Мөрөн сумын Хүүхдийн 1-р цэцэрлэг	3	28.5		-				-	3	28.5
Мөрөн сумын Хүүхдийн 15-р цэцэрлэг	2	12.6	1	11.3				-	1	1.3



Мөрөн сумын 10 дугаар цэцэрлэг	2	11.5	1	10.4				-	1	1.1
Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэг	1	1.4		-				-	1	1.4
Мөрөн сумын 8 дугаар цэцэрлэг	5	16.5	4	16.5				-	1	-
Эрдмийн далай цогцолбор сургууль	1	2.9	1	2.9				-		-
Мөрөн гурван эрдэнэ сургууль	1	3.2	1	3.2				-		-
Ирээдүй 21-р зуун цогцолбор сургууль	5	223.2	5	223.2				-		-
Мөрөн сум 13 дугаар цэцэрлэг	4	22.5	3	4.7				-	1	17.9
Мөрөн сум 7 дугаар цэцэрлэг	2	22.8	1	1.8				-	1	21.0
Мөрөн сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг	2	16.4		-				-	2	16.4
Мөрөн сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	1	35.2		-				-	1	35.2
Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг	1	89.9		-				-	1	89.9
Дүн	44	730.4	22	333.2	-	-	2	109.10	20	288.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Харьяа байгууллагуудын зөрчил										
Мөрөн сумын ЗДТГ	1	38.8							1	38.8
Мөрөн 2р цэцэрлэг	2	72.5							2	72.5
Мөрөн арван нэгдүгээр цэцэрлэг	2	284.2							2	284.2
Мөрөн арван хоёрдугаар цэцэрлэг	2	26.2							2	26.2
Мөрөн сумын Хүүхдийн 15-р цэцэрлэг	1	10.0							1	10.0
Мөрөн сум 13 дугаар цэцэрлэг	1	512.6							1	512.6
Мөрөн сум 7 дугаар цэцэрлэг	1	19.4							1	19.4
Дүн	15	963.7							15	963.7
Нийт дүн	63	2,045.0	22	333.2			2	109.1	29	1,602.7